

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.12.02

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

2024 он 12-р сарын 02

- Трамп Канад болон Мексикт 25 хувийн тариф ногдуулахаа мэдэгдсэн.
- Мөн Хятадын бүх импортын бараанд татварыг 10 хувиар нэмэгдүүлнэ.
- Инфляцыг хяналтдаа байлгах зорилгоор Скотт Бессентийг Сангийн сайдад нэр дэвшүүлэхээр боллоо.
- Хятадын Ардын Банк (PBoC) банкны системд 900 тэрбум юань нийлүүлж, зээлийн хүүг 2%-д хэвээр үлдээлээ.
- Хятад улс 83 тэрбум ам.долларын нөөцтэй алтны орд илрүүлжээ.

Dow Jones	44,910.65
S&P 500	6,032.40
Nasdaq	19,218.17
DAX	19,626.45
FTSE 100	8,287.30
S&P/ASX 200	8,436.70
HANG SENG	19,457.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	0.42%	0.39%	6.80%	19.16%	23.91%	29.87%
S&P 500	0.56%	0.75%	5.30%	26.47%	31.29%	32.92%
Nasdaq	0.83%	0.86%	5.36%	28.02%	34.35%	27.40%

2024 оны 12 сарын 02-ны 12:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	1.03%	1.14%	1.93%	17.16%	19.69%	29.38%
FTSE 100	0.07%	-0.05%	1.35%	7.16%	10.07%	16.36%

2024 оны 12 сарын 02-ны 12:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.02%	0.24%	3.93%	11.15%	19.29%	16.52%
Hang Seng	0.19%	1.61%	-5.11%	14.15%	15.62%	-18.12%

2024 оны 12 сарын 02-ны 12:00

ЗӨВЛӨМЖ

Биткойны арилжаанд оролцохдоо АНХААРАХ НЬ:

Хэрэв та Биткойн худалдан авахыг хүсвэл одоогийн дэмжлэгийн түвшинд (\$98,000)-д хэр удаан тогтож буйг ажиглан, 2024 он дуустал үнийн өсөлтийн боломжийг ашиглана үзэх нь зүйтэй. BTC ETF хөрөнгө оруулалт өсч буй нь зах зээлийн тогтвортой байдлыг харуулж байна.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хөрөнгийн зах зээл ба жижиг компаниудын өсөлт

Өнгөрсөн долоо хоногт Dow Jones, S&P 500 болон S&P 400 MidCap индексүүд шинээр бүх цаг үеийн дээд ханшаа тогтоож өсөлтөө бататгав. АНУ-д талархлын баяр болж пүрэв гарагт зах зээл амарч баасан гарагт тал ажилласан билээ. Харин өнгөрсөн сард S&P 500 5.73%-иар, Dow Jones Industrial Average 7.54%-иар тус тус өсөж энэ онд хамгийн сайн үзүүлэлттэй байв. Nasdaq Composite 6.21%-иар өссөн нь 5 сараас хойших хамгийн сайн үзүүлэлт болов.

### Трампын гаргасан шийдвэр

Хөрөнгө оруулагчдын сэтгэлзүйд дотоод бодлогын шийдвэр болон геополитикийн үйл явдлууд томоохон нөлөө үзүүлээ.

Сангийн сайдын томилгоо: Скотт Бессентийг Сангийн сайдад нэр дэвшүүлсэн нь хөрөнгө оруулагчдын дунд эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, инфляцыг хяналтдаа байлгах бодлого хэрэгжих найдвар төрүүлэв.

Тарифын төлөвлөгөө: Гэсэн хэдий ч тэр орой Трамп өөрийн Truth Social хуудаснаа Канад, Мексикээс импортлох бараанд 25%-ийн, Хятадаас импортлох бараанд 10%-ийн тариф ногдуулахаа мэдэгдсэн нь зах зээлд тодорхойгүй байдал үүсгэв.

### Хэрэглээний өсөлт ба үйлдвэрлэлийн уналт

Лхагва гарагт эдийн засгийн хэд хэдэн чухал үзүүлэлтүүд нийтлэгдсэн нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татав:

- Хувийн орлого, зарцуулалт: Аравдугаар сард хувийн орлого 0.6%-иар, зарцуулалт 0.4%-иар өссөн нь хүлээлтээс өндөр байлаа.
- Орон сууцны худалдаа: Хүлээгдэж буй орон сууцны борлуулалт 2.0%-иар өсөж, өмнөх сарын үзүүлэлт 7.5%-иар нэмэгдсэн нь сүүлийн 2 жилийн хамгийн өндөр өсөлт байв.
- Үйлдвэрлэлийн уналт: Батлан хамгаалах болон тээврийн бүтээгдэхүүнийг оролцуулалгүй тооцмон захиалга 0.2%-иар буурсан байна. Энэ нь үйлдвэрлэлийн салбарын сул байдлыг харууллаа.

### График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлт үзүүлээ.

- Shanghai Composite индекс 1.81%-иар өссөн бол
- CSI 300 индекс 1.32%-иар нэмэгдэв.
- Хонгконгийн Hang Seng индекс мөн 1.01%-иар өссөн байна.

Энэхүү өсөлт нь АНУ-ын тариф нэмэгдэх эрсдэлээс үл хамааран Хятадын засгийн газрын дэмжлэгийн талаарх найдвартай холбоотой байв.

### Хятадын Ардын Банкны бодлого

Хятадын Ардын Банк (PBoC) банкны системд 900 тэрбум юань нийлүүлж, зээлийн хүүг 2%-д хэвээр үлдээсэн.

- Гэсэн хэдий ч 11-р сард 1.45 их наяд юанийн зээлийн хугацаа дуусахтай холбоотойгоор цэвэр 550 тэрбум юань банкны системээс татагджээ.
- Орон нутгийн засгийн газрын бондын нэмэгдэл гаргалт нь оны эцэс хүртэл банкны системийн хөрвөх чадварт дарамт учруулна гэж шинжээчид үзэж байна.

Энэ нь Бээжингийн эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилтот бодлогыг нэмэгдүүлэх боломжийг улам бүр тодотгож байгаа аж.

Хятадын эдийн засагт засгийн газрын дэмжлэг өсөлтийг дэмжиж байгаа ч банкны системийн хөрвөх чадварын дарамт болон АНУ-ын тарифын эрсдэлүүд сорилт хэвээр үлдэж байна. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд Хятад 2025 онд нэмэлт бодлогын арга хэмжээнүүд хэрэгжүүлэх магадлалтай байна.

### График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

abligun published on TradingView.com, Nov 25, 2024 12:10 UTC+8

HSIHSEI, 1D O19,307.34 H19,351.06 L19,102.70 C19,131.82 -98.15 (-0.51%)



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 25, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
Bath & Body Works	zoom	Abercrombie & Fitch	DELL	GOOL				FRONTLINE	
Haidilao	BLUE BIRD	KOHL'S	CROWSTRIKE	QUANTASING				MINI	
BIOLINE	FLUENCE	BEST BUY	workday	arbe					
SPLASH	Agilent Technologies	macy's	AUTODESK	ColiPlant					
	WOODWARD	DICK'S	hp	HAFNIA					
	SEMTECH	Durlington	Ambarella						
	agora	ANALOG DEVICES	URBAN OUTFITTERS						
	HESAI	TEN LTD	3D SYSTEMS						
	LESLIES	Iris Energy							
	PennantPark	uCloudlink	NUTANI						
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning December 02, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
zscaler	Scotiabank	Salesforce	chewy	SentinelOne	DOLLAR GENERAL	lululemon	GENESCO		
CREDO	CORNING	OKTA	Foot Locker	AMERICAN EAGLE OUTFITTERS	TD Bank	UiPath			
	Donaldson	MARVELL	DOLLAR TREE	FIVE BELOW	WORKSHOP	ULTA			
	PURESTORAGE	BOX	RBC	synopsys	CanadianSolar	DocuSign			
	TORRID	box	THOR	chargepoint	SIGNET	GitLab			
	Couchbase	TORRID	Campbell's	PVH	BMO	Hewlett Packard Enterprise			
	DESCARTES	Couchbase	Cook Out	AeroVironment	METHODE ELECTRONICS	samsara			
	inotiv	DESCARTES	Hormel Foods	Incino	CALERES	Veeva			
		inotiv	DAKTRONICS	GREIF	Kroger	petco			
			Secureworks	VERINT	CIBC	asana			
http://eps.sh/cal						© 2024 Earnings Whispers			